



ОРХОН АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 05 сарын 10 өдөр

Дугаар 59

Эрдэнэт

Ээлжит хуралдаан  
зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 7 дахь удаагийн сонгуулийн Ээлжит VII хуралдааныг 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Эрдэнэт хотод зарлан хуралдуулж, дараах асуудал хэлэлцүүлэхээр тогтоосугай.

1.1.Баян-Өндөр уулыг орон нутгийн хамгаалалтад шинэчлэн авах тухай.

1.2.Аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журмыг шинэчлэн батлах тухай.

1.3.2016 оны улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үр дүн, Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт, Төрийн болон орон нутгийн өмчит байгууллагуудын санхүүгийн Аудитын нэгдсэн дүнгийн тухай.

1.4.Аймгийн 2016 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай.

1.5.Аймгийн 2017 оны төсвийн нэмэлт, өөрчлөлт батлах тухай.

Хоёр.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит VII хуралдааны бэлтгэл хангах арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

Гурав.Хуралдааны бэлтгэл хангаж хуралдуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга П.Пүрэвлхагвад даалгасугай.



ДАРГА П.ПҮРЭВЛХАГВА

C:\Togtool \-A4 doc

• 00100112